**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Малын удмын сангийн үндэсний төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2024/89/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn
Аудитор: П.Ариунзаяа
Утас: 261883 Цахим хаяг: ariunzayap@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг
Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/448
танай ____________-ны № ____________-т

МАЛЫН УДМЫН САНГИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
П.ГАНХУЯГ ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Малын удмын сангийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь шинж чанарын хувьд материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Малын удмын сангийн үндэсний төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 42,211.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.3, 6.4.5-д заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тус төв нь өөрийн үйлдвэрлэл болон импортоор нийт 4661 тун үр бэлтгэсэн, үйлдвэрлэлээр 7554 литр шингэн азот үйлдвэрлэсэн, 11.0 мянган тун гүн хөлдөөсөн үрээр 5 аймаг, 37 сумын 5500 үхэрт зохиомол хээлтүүлэг хийсэн байна.

**Аудитын гол асуудал**

Тус төв үндсэн үйл ажиллагааныхаа чиглэлээр "Нарийн болон нарийвтар ноост хонь үржүүлэх" төслийн хүрээнд Австралийн Мерино үүлдрийн хуцын 378 тун үрийг импортлон хүлээн авч 180 толгой хонинд зохиомол хээлтүүлэг, 148 толгой хонинд хөврөл шилжүүлэн суулгах ажлыг биотехнологийн дэвшилтэд арга дурангийн мэс ажилбарын аргаар хийж гүйцэтгэсэн, захиалгаар нийт 3709 үнээ, 5800 толгой хонинд хуцнаас үр авч шингэлсэн үрээр 3 үнээнээс хөврөл угааж 6 толгой үнээнд суулгах туршилт үйлдвэрлэлийн ажлыг хийсэн, ШУТИС болон Японы Токушима их сургуулийн хамтарсан багийн "Гени едитингийн технологи ашиглан Монгол улсад нарийн ширхэгт ноолуурын ямааны цөм сүргийг бий болгох" судалгааны төслийг амжилттай хэрэгжүүлж, цаашид 2 дахь шатны нийт 100.0 сая иеके санхүүжилт бүхий туршилт, үйлдвэрлэлийн төслийг боловсруулан Япон Улсын 2024 оны санхүүгийн жилээс эхлүүлэх техникийн хамтын ажиллагааны SATREPS хөтөлбөрт хамруулахаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Сангийн яам, Эдийн засаг, хөгжлийн яамнаас санал авч дэмжүүлэн Япон улсын Засгийн газарт хүргүүлж ажилласан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Тус төвийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, хэрэгжилтийг дээд шатны төсөв захирагчаас 87.5 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **10,013,695,402.78** | **12,437,751,221.47** |
| **33** | **АВЛАГА** | **799,147,166.85** | **935,082,288.36** |
| **33100** | **Ажиллагчидтай холбогдсон авлага** | **580,419.68** | **1,356,455.16** |
| 33102 | НДШ-ийн авлага | - | 615,348.00 |
| 33103 | ХАОАТ-ын авлага | 580,419.68 | 741,107.16 |
| **33300** | **Татаас, санхүүжилтийн авлага** | **-** | **4,000,000.00** |
| **33500** | **Бусад авлага** | **798,566,747.17** | **929,725,833.20** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 489,736,789.41 | 522,789,303.37 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 273,132,311.56 | 370,530,883.63 |
| 33530 | Ажилчдаас авах авлага | 35,697,646.20 | 36,405,646.20 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **74,960,000.00** | **70,860,000.00** |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 74,960,000.00 | 70,860,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **9,139,588,235.94** | **11,431,808,933.11** |
| 35100 | Түүхий эд материал | 333,780,434.70 | 198,248,066.31 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 308,834,284.70 | 184,292,966.31 |
| 35130 | Эм боох материал | 24,946,150.00 | 13,955,100.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 870,503,572.33 | 801,081,030.99 |
| 35400 | Хангамжийн материал | 128,097,237.11 | 92,661,615.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,305,000.00 | 311,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 45,597,000.00 | 45,601,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | 7,750,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 387,513.00 | 4,273,925.00 |
| 35460 | Хүнсний материал | - | 211,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 79,807,724.11 | 34,514,190.00 |
| 35600 | Мал амьтад | 7,807,206,991.80 | 10,339,818,220.81 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **16,435,779,826.53** | **15,664,685,529.89** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **16,435,779,826.53** | **15,664,685,529.89** |
| 39200 | Биет хөрөнгө | 15,651,561,026.62 | 14,890,658,396.50 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 14,510,509,919.37 | 14,483,559,221.69 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | (2,248,195,926.40) | (2,726,080,473.28) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 314,772,054.60 | 314,772,054.60 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | (205,800,084.10) | (230,156,306.76) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 3,846,335,448.15 | 3,846,335,448.15 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | (1,274,437,437.28) | (1,344,169,698.73) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 537,209,282.64 | 537,209,282.64 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | (316,622,231.73) | (376,892,421.46) |

| | | | |
|---|---|---|---|
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 591,219,754.00 | 591,219,754.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө | (133,671,397.03) | (235,380,108.75) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 30,241,644.40 | 30,241,644.40 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 784,218,799.91 | 774,027,133.39 |
| 39301 | Програм хангамж | 7,626,000.00 | 7,626,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | (4,826,000.09) | (5,892,666.61) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 781,418,800.00 | 772,293,800.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **26,449,475,229.31** | **28,102,436,751.36** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **117,083,350.97** | **117,946,020.17** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **117,083,350.97** | **117,946,020.17** |
| 41300 | Өглөг | 117,083,350.97 | 117,946,020.17 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,007,238.98 | - |
| 41311 | Цалингийн өглөг | 754,476.98 | - |
| 41313 | ХАОАТ-ын өглөг | 252,762.00 | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 13,048,496.61 | - |
| 413203 | Түлш халаалтын өглөг | 9,999,079.61 | - |
| 413204 | Цэвэр, бохир усны өглөг | 3,049,417.00 | - |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | 6,684,115.38 | 6,684,115.38 |
| 41360 | Бусад өглөг | 96,343,500.00 | 111,261,904.79 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 96,343,500.00 | 111,124,947.50 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | 136,957.29 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **26,332,391,878.35** | **27,984,490,731.19** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **26,332,391,878.35** | **27,984,490,731.19** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,496,570,935.15 | 1,496,570,935.15 |
| 511001 | Засгийн газрын оруулсан капитал засгийн газрын сан | 1,496,570,935.15 | 1,496,570,935.15 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 24,248,207,482.92 | 25,916,709,213.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 22,678,030,389.46 | 24,265,449,943.73 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 1,570,177,093.46 | 1,651,259,269.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 587,613,460.28 | 571,210,582.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **26,449,475,229.31** | **28,102,436,751.36** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **4,422,054,376.78** | **4,732,263,825.78** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,326,910,076.78** | **3,294,356,725.78** |
| **1200** | **Нийтлэг татварын бус орлого** | **2,326,910,076.78** | **3,294,356,725.78** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 163,920,372.92 | 201,509,299.52 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 14,310,444.44 | 144,846,571.32 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 98,833,158.31 | 36,261,628.20 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 50,776,770.17 | 20,401,100.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 22,663,288.86 | - |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | 2,140,326,415.00 | 3,092,847,426.26 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,095,144,300.00** | **1,437,907,100.00** |
| **1310** | **Улсын төсвөөс** | **2,090,363,300.00** | **1,428,363,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,090,363,300.00 | 1,428,363,100.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **4,781,000.00** | **9,544,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,781,000.00 | 9,544,000.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **2,814,084,297.52** | **2,954,295,650.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,814,084,297.52** | **2,954,295,650.51** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,802,758,113.99** | **2,912,533,226.51** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **483,838,030.73** | **619,978,928.65** |
| 210101 | Үндсэн цалин | 369,026,178.39 | 400,232,387.64 |
| 210102 | Нэмэгдэл | 58,937,262.34 | 110,965,176.81 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 49,260,000.00 | 88,108,000.00 |
| 210104 | Урамшуулал | 6,614,590.00 | 20,673,364.20 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **61,138,419.45** | **78,940,878.29** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 42,847,061.62 | 54,740,159.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,040,830.42 | 6,440,018.97 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,871,384.70 | 4,993,615.11 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 852,649.59 | 1,137,263.98 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,526,493.12 | 11,629,820.41 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **118,421,817.29** | **130,771,955.68** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,588,598.29 | 34,226,276.68 |
| 210302 | Түлш, халаалт | 71,963,276.00 | 87,378,572.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,989,943.00 | 5,207,107.00 |
| 210304 | Байрны түрээс | 11,880,000.00 | 3,960,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **160,927,247.75** | **185,254,187.20** |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 7,569,350.00 | 9,041,612.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,545,431.20 | 38,322,144.90 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,160,385.87 | 1,896,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,737,330.00 | 528,489.94 |
| 210408 | Бараа материал актласны зардал | 108,914,750.68 | 135,465,940.36 |
| **2105** | **Нормативт зардал** | **25,966,310.80** | **37,646,150.06** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,310,270.00 | 23,453,410.00 |
| 210502 | Хоол, хүнс | 8,656,040.80 | 14,192,740.06 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **18,052,576.54** | **14,189,300.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 817,676.54 | 250,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 17,234,900.00 | 13,939,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,548,160.00** | **8,749,248.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,548,160.00 | 8,749,248.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **542,042,858.71** | **510,087,213.87** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 530,577,050.71 | 503,262,910.87 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 2,499,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 115,830.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 549,978.00 | 124,503.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,800,000.00 | 4,200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **1,388,822,692.72** | **1,326,915,364.76** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 722,902,746.30 | 586,565,399.67 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 665,919,946.42 | 740,349,965.09 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,326,183.53** | **41,762,424.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,728,247.00** | **29,986,869.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,878,247.00 | 9,510,789.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | - | 20,476,080.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 850,000.00 | - |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **597,936.53** | **11,775,555.00** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 597,936.53 | 11,775,555.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **1,607,970,079.26** | **1,777,968,175.27** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **37,792,985.80** | **126,708,905.68** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **37,792,985.80** | **126,708,905.68** |
| **225010** | Үнэ төлбөргүй гарсан зардал - үндсэн хөрөнгө | - | 31,583,914.80 |
| 225011 | Үнэ төлбөргүй гарсан зардал зардал - бараа материал | 37,792,985.80 | 95,124,990.88 |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **1,570,177,093.46** | **1,651,259,269.59** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,349,800,503.90** | **1,764,232,975.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **254,656,203.90** | **326,325,875.00** |
| **1200** | **Нийтлэг татварын бус орлого** | **254,656,203.90** | **326,325,875.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 254,656,203.90 | 326,325,875.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 115,379,667.16 | 126,882,225.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 139,276,536.74 | 199,443,650.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,095,144,300.00** | **1,437,907,100.00** |
| **1310** | **Улсын төсвөөс** | **2,090,363,300.00** | **1,428,363,100.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,090,363,300.00 | 1,428,363,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 4,781,000.00 | 9,544,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 4,781,000.00 | 9,544,000.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **2,214,336,707.28** | **1,764,232,975.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,214,336,707.28** | **1,764,232,975.00** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **2,203,010,523.75** | **1,718,470,551.00** |
| **2101** | **Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил** | **415,642,311.47** | **617,840,088.41** |
| 210101 | Үндсэн цалин | 293,147,095.53 | 407,439,814.14 |
| 210102 | Нэмэгдэл | 67,229,054.05 | 110,646,324.50 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 48,703,218.41 | 81,517,793.25 |
| 210104 | Урамшуулал | 6,562,943.48 | 18,236,156.52 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **52,127,347.45** | **82,158,603.99** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,089,213.62 | 58,604,403.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,245,789.42 | 5,888,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,315,991.70 | 4,710,900.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 770,577.59 | 1,177,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,705,775.12 | 11,777,100.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **206,448,350.29** | **181,917,502.29** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 26,588,598.29 | 34,226,276.68 |
| 210302 | Түлш, халаалт | 165,468,626.00 | 131,514,701.61 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,940,526.00 | 8,256,524.00 |
| 210304 | Байрны түрээс | 9,450,600.00 | 7,920,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **16,746,985.87** | **18,384,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,362,400.00 | 1,147,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,619,700.00 | 10,767,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,160,385.87 | 1,896,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,604,500.00 | 4,572,600.00 |
| 2105 | Нормативд зардал | 2,685,000.00 | 300,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 164,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,521,000.00 | 300,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **21,436,576.54** | **34,565,900.00** |

| | | | |
|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 817,676.54 | 1,153,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 20,618,900.00 | 33,412,900.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **3,700,660.00** | **8,880,548.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,700,660.00 | 8,880,548.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **1,479,676,318.06** | **770,887,408.31** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,479,010,510.06 | 764,063,105.31 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 2,499,800.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 115,830.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 549,978.00 | 124,503.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 4,200,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **4,546,974.07** | **3,536,500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,546,974.07 | 3,536,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **11,326,183.53** | **45,762,424.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **10,728,247.00** | **29,986,869.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,878,247.00 | 9,510,789.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | 20,476,080.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 850,000.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 597,936.53 | 15,775,555.00 |
| **213303** | **Төвлөрүүлэх шилжүүлэг** | **597,936.53** | **15,775,555.00** |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **135,463,796.62** | **-** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | **-** | **-** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **135,467,299.62** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **135,467,299.62** | **-** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **135,467,299.62** | **-** |
| 2251 | Үндсэн хөрөнгө олж бэлтгэхэд төлсөн | 135,467,299.62 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 135,467,299.62 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V) | (135,467,299.62) | - |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII) | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | (3,503.00) | - |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,503.00 | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **1** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,496,570,935.15** | **587,613,460.28** | **22,678,030,389.46** | **24,762,214,784.89** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,496,570,935.15** | **587,613,460.28** | **22,678,030,389.46** | **24,762,214,784.89** |
| 9 | Тайлант үеийн үр дүн | | | 1,570,177,093.46 | 1,570,177,093.46 |
| **11** | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,496,570,935.15** | **587,613,460.28** | **24,248,207,482.92** | **26,332,391,878.35** |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 17,242,460.81 | 17,242,460.81 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,496,570,935.15 | 587,613,460.28 | 24,265,449,943.73 | 26,349,634,339.16 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | (16,402,877.56) | | (16,402,877.56) |
| **19** | **Тайлант үеийн үр дүн** | | | **1,651,259,269.59** | **1,651,259,269.59** |
| **20** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,496,570,935.15** | **571,210,582.72** | **25,916,709,213.32** | **27,984,490,731.19** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,829,955,900.00** | **1,738,913,420.00** | **91,042,480.00** | **95.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,829,955,900.00** | **1,738,913,420.00** | **91,042,480.00** | **95.0** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,791,568,900.00** | **1,708,926,551.00** | **82,642,349.00** | **95.4** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **657,272,000.00** | **617,840,088.41** | **39,431,911.59** | **94.0** |
| 210101 | Үндсэн цалин | 460,475,100.00 | 407,439,814.14 | 53,035,285.86 | 88.5 |
| 210102 | Нэмэгдэл | 152,399,400.00 | 110,646,324.50 | 41,753,075.50 | 72.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 21,549,700.00 | 81,517,793.25 | -59,968,093.25 | 378.3 |
| 210104 | Урамшуулал | 22,847,800.00 | 18,236,156.52 | 4,611,643.48 | 79.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **111,030,400.00** | **82,158,603.99** | **28,871,796.01** | **74.0** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 87,476,200.00 | 58,604,403.99 | 28,871,796.01 | 67.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 5,888,500.00 | 5,888,500.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,710,900.00 | 4,710,900.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,177,700.00 | 1,177,700.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 11,777,100.00 | 11,777,100.00 | - | 100.0 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **191,522,100.00** | **181,917,502.29** | **9,604,597.71** | **95.0** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 39,002,100.00 | 34,226,276.68 | 4,775,823.32 | 87.8 |
| 210302 | Түлш, халаалт | 131,535,200.00 | 131,514,701.61 | 20,498.39 | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 13,248,900.00 | 8,256,524.00 | 4,992,376.00 | 62.3 |
| 210304 | Байрны түрээс | 7,735,900.00 | 7,920,000.00 | (184,100.00) | 102.4 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14,502,800.00** | **14,232,000.00** | **270,800.00** | **98.1** |
| 210401 | Бичиг хэрэг | 1,418,700.00 | 1,147,900.00 | 270,800.00 | 80.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,447,500.00 | 9,447,500.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,896,000.00 | 1,896,000.00 | - | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,740,600.00 | 1,740,600.00 | - | 100.0 |
| **2105** | **Нормативт зардал** | **1,235,600.00** | **300,000.00** | **935,600.00** | **24.3** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,235,600.00 | 300,000.00 | 935,600.00 | 24.3 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **34,735,900.00** | **34,565,900.00** | **170,000.00** | **99.5** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,323,000.00 | 1,153,000.00 | 170,000.00 | 87.2 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 33,412,900.00 | 33,412,900.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,405,300.00** | **6,048,548.00** | **356,752.00** | **94.4** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,405,300.00 | 6,048,548.00 | 356,752.00 | 94.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **771,328,300.00** | **768,327,408.31** | **3,000,891.69** | **99.6** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 763,053,700.00 | 761,503,105.31 | 1,550,594.69 | 99.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,499,800.00 | 200.00 | 100.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 76,400.00 | 0.00 | 76,400.00 | 97.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 151,000.00 | 124,503.00 | 26,497.00 | 82.5 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 81,600.00 | | 81,600.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,800,000.00 | 4,200,000.00 | 600,000.00 | 87.5 |
| 210807 | Газрын төлбөр | 665,600.00 | | 665,600.00 | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **3,536,500.00** | **3,536,500.00** | **-** | **100.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 3,536,500.00 | 3,536,500.00 | - | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,387,000.00** | **29,986,869.00** | **8,400,131.00** | **78.1** |
| **213204** | **Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал** | **15,054,000.00** | **9,510,789.00** | **5,543,211.00** | **63.2** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,916,100.00 | 20,476,080.00 | 1,440,020.00 | 93.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,416,900.00 | - | 1,416,900.00 | - |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,829,955,900.00** | **1,738,913,420.00** | **91,042,480.00** | **95.0** |
| **1320** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,829,955,900.00** | **1,738,913,420.00** | **91,042,480.00** | **95.0** |
| 122005 | Улсын төсвөөс | 1,829,955,900.00 | 1,738,913,420.00 | 91,042,480.00 | 95.0 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | **-** | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **34** | **34** | **-** | **100.0** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 31 | 31 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 2 | 2 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **9,544,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **9,544,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **9,544,000.00** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **4,152,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1,320,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,832,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 2,832,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2,832,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **2,560,000.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 2,560,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **9,544,000.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **9,544,000.00** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 9,544,000.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 212,623.0 мянган төгрөгийн 6 алдаа[1] илэрснээс аудитын явцад 212,623.0 мянган төгрөгийн алдааг бүрэн залрууллаа.

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Нэр бүхий иргэдээс авах өмнөх оны авлагын төлөлт 7,224.0 мянган төгрөгийг орлогоор тайлагнасан байна. | 1 | 7,224.0 | | | 1 | 7,224.0 | 1 | 7,224.0 | | | | |
| Үндсэн хөрөнгөнд элэгдэл илүү байгуулж үлдэгдэл өртгийг сөрөг утгатай тайлагнасан байна | 1 | 839.6 | - | - | 1 | 839.6 | 1 | 839.6 | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгөөс үндэслэлгүй хассан 1,189.0 мянган төгрөгийн хасалтын буцаасан | 1 | 1,189.0 | | | 1 | 1,189.0 | | 1,189.0 | | | | |
| Орлого үр дүнгийн тайланд байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогын дүнг 164,690.4 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан. | 1 | 164,690.4 | - | - | 1 | 164,690.4 | 1 | 164,690.4 | - | - | - | - |
| Хандив тусламжаар үнэ төлбөргүй ирсэн бараа материалын 34,924.8 мянган төгрөгийг нэмэлт санхүүжилтээр тайлагнасан. | 1 | 34,924.8 | | | 1 | 34,924.8 | 1 | 34,924.8 | | | | |

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Өглөгийн дэлгэрэнгүй бүртгэлд 1 харилцагчийн үлдэгдлийг сөрөг утгатай тайлагнаснаар өглөгийн дүн 3,755,2 мянган төгрөгөөр буурсан. | 1 | 3,755.2 | | | 1 | 3,755.2 | 1 | 3,755.2 | | | | |
| **Дүн** | **6** | **212,623.0** | **-** | **-** | **6** | **212,623.0** | **5** | **212,623.0** | **-** | **-** | **-** | **-** |

Аудитаар нийт 470,735.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 446,722.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 албан шаардлага хүргүүлж, 24,013.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд 372,505.5 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээний худалдан авалтыг шууд гэрээгээр гүйцэтгэсэн байна. | 1 | 372,505.5 | - | - | 1 | 372,505.5 | | - | - | - | - | - |
| Авлага өмнөх оноос 131,227.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн, 74,216.6 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна. | 1 | 74,216.6 | - | - | 1 | 74,216.6 | - | - | - | - | - | - |
| Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 241 нэр төрлийн 936,850.8 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгааг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | - |

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Томилолтын зардлын 24,013.4 мянган төгрөгийн 30 гүйлгээг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаар тайлагнасан байна. | 1 | 24,013.4 | - | - | - | - | 1 | 24,013.4 | - | - | - | - |
| **Дүн** | **4** | **470,735.5** | **-** | **-** | **2** | **446,722.1** | **2** | **24,013.4** | **-** | **-** | **-** | **-** |

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 1,704,319.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,704,319.2 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүллээ.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 9 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 329,983.5 мянган төгрөгийн 24 гүйлгээг, орлогын 1,374,335.7 мянган төгрөгийн 32 гүйлгээг тус тус мэдээлээгүй байна. | 1 | 1,704,319.2 | - | - | 1 | 1,704,319.2 | - | - |
| **Дүн** | **1** | **1,704,319.2** | **-** | **-** | **1** | **1,704,319.2** | **-** | **-** |